



Р.УУГАНБАЯР

Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн багш, ахлах дэслэгч

ЯЛТНЫ ЗҮГЭЭС ҮЙЛДЭГДЭЖ БҮЙ ГЭМТ ХЭРЭГ, ЭРХ ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар хорих байгууллага нь хорих ялыг албадан эдлүүлэх, ялтны аюулгүй байдлыг хангаж, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, ялтнаас нийгэм иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх зэрэг бусад арга хэмжээг зохион байгуулах тусгай чиг үүрэгтэй төрийн байгууллага мөн.


Нөгөө талаас энэхүү чиг үүрэг нь эрүүгийн хариуцлагын зорилго /иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх,

урьдчилан сэргийлэх/-оос урган гарсан хэмээн үзэж болно.

Судлаач эрдэмтэдийн үзэл бодол, ял эдлүүлэх практикаас үзвэл хорих ялын зорилтыг хангах, үр нөлөөг нь дээшлүүлэх үндсэн нөхцөл нь ял эдлүүлэх дэглэмийн оновчтой тогтолцоо, түүнд тохирсон нөхцөл, эрх зүйн зохицуулалт мөн. Гэтэл өнөөдөр үйлчилж буй Монгол Улсын хорих байгууллагын төрөл, дэглэм нь ял эдлэгсдэд үзүүлэх нөлөөлөл багатай, өөр хоорондоо төдийлөн ялгарахаа больсноор барахгүй зарим тохиолдолд ялын зорилтыг хангахад сөргөөр нөлөөлөх болсон. Тухайлбал: Чанга, онцгой дэглэмтэй хорих ангид ял эдлэгсдийн хувьд хөдөлмөрт татагдан иргэн, нийгэмд учруулсан хохирлоо төлөх, хөдөлмөрийн дадал хэвшилтэй болох явдал нь эрх зүйн зохицуулалтаас болоод маш хязгаарлагдмал байна.

Иймд чанга, онцгой дэглэмийн хорих ангид ял эдлэгсдийн хувьд чөлөөт цаг нь улам ихсэж өөрийн сонирхсон сургалт, олон нийтийн /урлаг, спортын/ ажилд хамрагдах, зурагт үзэх, ном сонин унших зэргээр багагүй цагаа өнгөрүүлж байна. Энэ нь нөгөө талаас ялтнуудаас бие биеэ судлах, гэмт


ГЭМТ ХЭРГИЙН СУДАЛГАА



гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс

үйлдлийн аргад харилцан суралцах, зохион байгуулалтад орох, хүчгүй сул дорой нэгнээ

ЗӨРЧЛИЙН СУДАЛГАА



дээрэлхэх, өөрийн эрх ашиг хүсэл сонирхолдоо нийцүүлэн хөдөлгөх /үйлдэл хийлгэх/, аливаа хэлбэрээр /жишээ нь: өмнө нь амьдарч байсан аймаг, хот, сум, дүүрэг, суралцаж байсан сургууль эсвэл хөрөнгө чинээ, сонирхол, хобби зэргээр/ хамтран бүлэглэл үүсгэх нөхцөл боломжийг бий болгож байна.

Мөн хорих ял эдлэгсдийн бүтцэд судалгаа хийж үзвэл 2013 оны жилийн эцсийн байдлаар нийт 6900 гаруй ялтан хорих ял эдэлж байгаагаас 50 гаруй хувь нь 15 ба түүнээс дээш жилийн ялтай, 35% нь хүнд онц хүнд, тэр дотроо хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн, 70% нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн, 49,4% нь хоёр ба түүнээс дээш удаа хорих ял эдэлж байгаа /3-аас дээш удаа ял эдэлж байгаа ялтан нийт ялтны 15 % -ийг эзэлдэг/¹⁴ ялтнууд байна.

Түүнчлэн ШШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газраас нэгтгэсэн статистик тоон мэдээнээс үзвэл хорих байгууллагад ялтны зүгээс 2009 онд 19 гэмт хэрэг, 1030 зөрчил, 2010 онд 18 гэмт хэрэг, 1101 зөрчил, 2011 онд 9 гэмт хэрэг, 1795 зөрчил, 2012 онд 24 гэмт хэрэг, 1956 зөрчил, 2013 онд 24 гэмт хэрэг, 2082 зөрчлийг тус тус гаргажээ.

Статистикийн энэхүү судалгаанаас үзвэл хорих байгууллагад ялтны зүгээс үйлдэж буй гэмт хэрэг, эрх зүйн зөрчил тооны хувьд нэмэгдсний гадна аюул занал нь Монгол Улсын Шүүхээр 2013 онд 8324 хүнд холбогдох 6161 эрүүгийн хэрэг шийдвэрлэгдсэний 539 нь давтан, 995 нь 2 ба түүнээс дээш удаа, 22 гэмт этгээдийг онц аюултай гэмт хэрэгтнээр тооцсон байна. Түүнчлэн өнөөдөр хорих байгууллагад ял эдэлж буй 7000 орчим ялтны 49.9 хувь нь 2 ба түүнээс дээш ял шийтгэгдсэн, 200 орчим ялтан онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон байна.

Өөрөөр хэлбэл нууц далд аргаар дахин, давтан гэмт хэрэг үйлдэх хандлага бий болон туршлагажиж байна. Энэ нь эрх зүйн зохицуулалт оновчтой бус, хорихоос суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх тогтолцоо хангатгүй, хувь хүний хүмүүжил, төлөвшил, нийгмийн ёс суртахуунтай холбоотой. Хорих байгууллагад голчлон бусдын амь нас, бие, эд хөрөнгөд халдсан шинжтэй гэмт хэргийг түлүү үйлдэж байна. тухайлбал 2013 оны жилийн эцсийн байдлаар нийт ялтны зүгээс үйлдэгдсэн гэмт хэрэг, гарах болсон шалтгааныг авч үзвэл:

¹⁴ ШШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газрын 2013 оны тайлан

➤ Хүний амь нас хохироосон-1 \уг гэмт хэрэг нь шууд санаатай үйлдэгддэг ба ялтан хоорондын харьцаанаас/

➤ Хүний эрүүл мэндэд гэмтэл учруулсан-14 \албан хаагчийн ялтанд тавих хяналт сул, албаны сонор сэрэмж муу, хорих байгууллагын харуул хамгаалалтанд ашиглаж байгаа техник хэрэгслийн хүчин чадал муу зэргээс шалтгаалан уг гэмт хэрэг гарах үндэс суурь бүрдэж байна.\

➤ Хулгай хийсэн-2 \ гадна заалт, хэсэг салбарт ажиллаж байгаа ялтнууд дээр тавих хяналт сул, гадна заалт хэсэгт гарах ялтанд хийх нийгмийн ажилтан сэтгэл зүйч, төлөөлөгч нарийн судалгаа муу байна \

➤ Залилан -1 \ ялтны дунд гар утас ашиглах сонирхол ихэссэн, гар утсаар дамжуулан интернет, мобайл банк зэргийг ашиглан гэмт хэрэг үйлдэх арга хэрэгсэлээ болгож байна.\

➤ Оргосон-4 \ оргох гэмт хэрэг гарах шалтгаан нь ял эдлэх нөхцөлийн улмаас, гэмт хэргийн нөхцөл байдлаас, дарамт шахалтаас болж, ар гэрийн нөхцөл байдлаас үүдэн үйлдэгдэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хуулийн 115-р зүйлд заасны дагуу ялтан нь дараах үүрэг хүлээн¹⁵. Үүнд:

-Баривчлах байр, хорих ангид мөрдөх хууль тогтоомж байгууллага, ажилтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх

-Эрх бүхий албан тушаалтнаас даалгасан ажлыг заавал гүйцэтгэх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмыг чанд сахиx

-Тогтоосон журмын дагуу зохиож байгаа хөдөлмөрийн дадлага олгох болон ерөнхий сургалтанд хамрагдах

-Эрүүл мэндээ хамгаалах, эмчийн зөвлөлгөө шаардлагыг биелүүлэх,

хуурамчаар болон санаатайгаар өвчилсөн, эрүүл мэнд, бие эрхтэндээ гэмтэл учруулсан бол холбогдох зардлыг төлөх

-Эзэмшиж байгаа эд хөрөнгө, хөдөлмөрийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжид хайр гамтай хандах зэрэг болно.

Хорих ангийн дотоод журмийн 9-р зүйлд заасны дагуу ялтан дараах эд зүйлсийг биедээ хадгалаж хэрэглэж болно. Үүнд: боловсруулсан хүнсний болон гурилан бүтээгдэхүүн, ариун цэврийн болон ахуйн хэрэгцээний зүйлс, бугуйн цаг, аллага хүчихийлэл садар самууныг сурталчилснаас бусад сонин ном сэтгүүд, нормын болон ээлжийн дотуур хувцас, спортын хувцас, хөлөгт тоглоом, гэр бүлийн гишүүдийн фото зураг, засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих доод төвшингийн 10%-тай тэнцэх хэмжээний бэлэн мөнгө хэрэглэхийг зөвшөөрөх ба дээрх зүйлсээс бусад зүйлс хэрэглэсэн, нуусан, хориглосон үйлдэл үзүүлсэн тохиолдолд зөрчилд тооцдог. Мөн зарим төрлийн эрх зүйн зөрчил нь гэмт хэрэг гарах шууд шалтгаан нөхцөл болдог. 2013 онд ялтны зүгээс үйлдсэн зөрчлийн байдлыг судлан авч үзвэл:

➤ Ажил хийхээс зайлсхийсэн-6 \хорих ангийн үйдвэрлэлний үйл ажиллагаанд оролцохоос санаатайгаар зайлсхийх хуурамчаар өвчлөх, багаж тоног төхөөрөмжийг санаатайгаар эвдэх зэргээр ялтнууд ажил хөдөлмөр эрхлэх сонирхолгүй байдаг \

➤ Ажлын байр, хорих ангиас дур мэдэн явсан-9 \ялтнууд хэсэг салбарт гарч ажиллаж байхдаа тухайн ажиллаж байгаа газраа дур мэдэн орхиж явдаг \

➤ Бусдыг дарамталж эд зүйлс булаасан-34 \ялтнууд цуг ял эдэлж байгаа сул дорой нэгнээ дарамталж материаллаг эд

¹⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай МУ-ын хуулийн 115-р зүйл

зүйлс мөнгө, хувцас зэрэг зүйлс булаах дээрэмдэх асуудал\

➤ Бие эрхтэндээ санаатай гэмтэл учруулсан-9 \ялтнууд хорих ял эдлэхээс зайлсхийж бусад шалтгаанаар бие эрхтэндээ санаатай гэмтэл учруулж байна\

➤ Архи уусан-132 \ялтнууд ялангуяа жирийн дэглэмтэй ялтнууд хэсэг салбарт ажиллаж байхдаа архи согтууруулах ундаа хэрэглэх явдал таслан зогсоогдохгүй байнгын өсөх хандлагатай байна. Энэ зөрчил гарах болсон шалтгаан нь албан хаагчийн сахилга хариуцлага сонор сэрэмж алдсан мөн тэдэнтэй хувийн харьцаа тогтоох, үзлэг нэгжлэг хангалтгүй хийдэг зэргээс шалгаалж байна. Түүнчлэн зарим тохиолдолд ялтны амьдралын бүсэд согтууруулах ундааны зүйл бэлтгэх, нууцаар оруулах зөрчил гарсаар байна \

➤ Хориотой тоглоом тоглосон-23 \хорих ангид ял эдэлж буй ялтнууд хорих ангийн дотоод журам зөрчиж мурийтай хөзөр, шатар бусад тоглоом тоглож хорих ангийн дотоод журам зөрчих асуудал их гарч байна. Ялангуяа баяр тэмдэглэлт явдлын үеэр\

➤ Албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлага эсэргүүцсэн-111 \хорих ангийн дотоод журамд заасны дагуу албан хаагчын тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн, албан хаагч руу халдсан доромжилсон, заналхийлэх зэргээр илэрдэг.\

➤ Гар утас-1436 \нийт хорих ангид ял эдэлж байгаа ялтнууд гар утас хэрэглэж ар гэртэйгээ холбогдох, бусдыг дарамтлах дахин гэмт хэрэг үйлдэхэд бэлтгэх, ялтнууд хоорондоо утсаар холбогдож хорих ангийн нөхцөл байдлыг талаар мэдээлэл солилцох хоорондоо

холбогдож хорих ангийн дотоод нөхцөл байдал\ зэрэг зөрчил гарсан байна¹⁶.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад ялтан бие хүнийг судлах нь томоохон байр, суурь эзэлдэг, чухал зангилаа асуудал билээ. Ялтан бие хүнийг төлөвшсөн онцлогийг судлахгүйгээр гэмт хэргийн шалгаан, нөхцөлийг илрүүлж, арилгах, хүнийг хүмүүжүүлэх, гэмт хэрэг, зөрчид үйлдэхээс урьдчилан сэргийлэх асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм. Гэмт хэрэгтэн бие хүнийг судлах судалгааны зорилго бол амьдралын тодорхой нөхцөлд тухайн хүний зан төрхийн онцлогт тохирсон шийдвэр гаргаж, түүнд эерэг байдлаар нөлөөлөх, гэмт зан төлөв үүсэх буюу төлөвшин тогтох, бие хүн түүний орчны харилцан үйлчлэлийн механизмыг олж илрүүлэх, улмаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөв чиглэлийг тодорхойлоход оршино.

1. Хорих ял эдлэгсэдээс үйлдэж буй зөрчил, гэмт хэрэг бүгдийг цаг алдалгүй илрүүлэн таслан зогсоож хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг шуурхай явуулан шийдвэрлэж зөрчлийн болон ялтны хувийн байдалд нь тохирсон хариуцлагыг эргэлт буцалтгүй заавал ноогдуулах механизмыг нэг мөр төлөвшүүлэх.

Учир нь хорих байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн мэдээнд гэмт хэргийн шинжтэй зарим үйлдэлийг сахилгын төрөлд тооцон хариуцлага хүлээлгэдэг практик түгээмэл байна. \жишээ нь: хорих ангийн байрлалыг дур мэдэн орхиж явах, бусдын биед гэмтэл учруулах, танхайрах, хулгайлах гэх мэт\

2. Хорих ял эдлэгсдийн чөлөөт цаг их сургалт, хөдөлмөрт татагдан орох хугацаа нь бага байгаатай уялдан сэлгүүцэх хий дэмий цаг өнгөрөөж уйдах улмаар гэмт хэрэг

¹⁶ ТГГ-ын тайлан 2013 он

зөрчил гаргах, тэдгээрт бие биеээсээ суралцах сэдэл ч үүсэх боломжтойг үгүйсгэх аргагүй. Иймээс ялтны дунд зохион байгуулах нийгэмшүүлэх ажлыг эрчимжүүлэх

3. Ял эдлэгсдийг тусгаарласан хэсэг салбарыг бодитойгоор бий болгох

Жишээ нь: дэглэм буурсан ялтануудыг, удаа дараа хорих ял эдлэгсдийг тусад нь ял эдлүүлэх. Мөн энэ хүрээнд эдийн засгийн, зохион байгуулалттай гэмт хэргийн оролцогчид, шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллага болон төрийн албанд ажиллаж байсан ялтнуудын асуудлыг хамаарна.

4. Хорих байгууллагын харуул хамгаалалтын техник хэрэгсэл ялангуяа хяналтын камерын стандартыг нэг мөр тогтоох шаардлагатай. Мөн тэдгээрийг байршуулах, үйл ажиллагаандаа ашиглах, бичлэгийг хадгалах журмыг нэгдсэн байдлаар тогтоох нь зохих ач холбогдолоо өгнө гэж үзсэн.

5. Хорих байгууллагад гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд орчин үеийн дэвшилтэт техник, хэрэгсэл, гүйцэтгэх ажлын арга хэрэгслийг ашиглах

6. ШШГТХ хэрэгжээд 10 гаруй жил өнгөрч зохицуулж байсан нийгмийн харилцаанд ихээхэн өөрчлөлт гарсантай уялдуулж энэ хуультай нийцүүлэн гаргасан тушаал, шийдвэр, заавар, журмыг шинэчлэх шаардлагатай дээр шинэчлэн найруулсан хуулийн төслийг системийн хэмжээнд ажиллаж байгаа нийт албан хаагчдад хүргүүлж, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

**Шийдвэр гүйцэтгэгчдийн нэгдсэн
зөвлөгөөнд тавьсан илтгэлээс**

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН
БАТАЛГААГ ГАДААДЫН ЗАРИМ
ОРОНД БҮРДҮҮЛСЭН БАЙДАЛ**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь төрийг төлөөлж, хууль сахиулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг явуулдгийн хувьд үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хүний эрхийг хүндэтгэн хамгаалах зарчмыг ямагт мөрдөх ёстой билээ. Нөгөөтэйгүүр тус байгууллагын ажилтнуудыг үйл ажиллагаагаа хараат бус, үр дүнтэй явуулах эрх зүйн болон нийгмийн баталгааг төр бүрдүүлж өгөх үүрэгтэй. Тодруулбал, шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахад түүний албан хаагчийн ажиллах, нөхцөл, эрх зүйн болон нийгмийн баталгаа, эрүүл мэндийг хамгаалан хангахтай холбогдсон асуудлыг шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох нь төрийн өөрийнх үүрэг юм.

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 137 дугаар зүйлд шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн баталгааг бүрдүүлж өгсөн байдаг. Харин энэ төрлийн баталгааг дэлхийн зарим оронд хэрхэн бүрдүүлсэн байдаг талаар товч мэдээллийг та бүхэнд танилцуулья.

1. Юуны өмнө зарим оронд шийдвэр гүйцэтгэгчийн амь нас, аюулгүй байдалтай холбоотой эрх зүйн баталгааг хэрхэн бүрдүүлсэн байдаг талаар авч үзье.

Оросын Холбооны Улсад Эрүүгийн хариуцлагыг хорих ялаар гүйцэтгэхб айгууллагуудын тухай хуулийн

дугаарбүлэгтэрүүгийнхэргийншийдвэргүйцэтгэхсистемийнажилтнуудынэрхзүйнболоннийгмийнбаталгаагхуульчилсанбайдаг. Энэхуулиар шийдвэр гүйцэтгэх газрынажилтнууд болон түүний гэр бүлийнхнийаюулгүй байдлыг хангах нь төрийн үүрэг болохыг тодорхойлж, уг байгууллагынажилтнуудын нэр төр, алдар хүндийгхуулиар хамгаалахаар заажээ.

Тус хуулийн 33 дугаар зүйлд зааснаар тогтоол гүйцэтгэх газрын ажилтнууд, түүний гэр бүлийнхний амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахдаа тэдгээрийн оршин сууж буй газрыг олон нийтээс нууцалдаг. Эрх зүйн энэ төрлийн баталгааг ОХУ-аас гадна мөн Украин, Узбекистан, Казахстан зэрэг улсад хуульчилсан ба Украин улсын Эрүүгийн хэргийн шийдвэрийг гүйцэтгэх албаны тухай хуулиар иргэд, олон нийтэд шийдвэр гүйцэтгэх албаны ажилтнуудын болон гэр бүлийн оршин сууж байгаа газрын хаягийг тараахыг хориглосон байдаг.

Монголтой ойрын хөрш Казахстан Улсын тухайд Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нарын эрх зүйн байдал ба шийдвэр гүйцэтгэх журмын тухай хууль үйлчилж байна. Тус улсад шийдвэр гүйцэтгэгч нь төрийн болон хувийн гэсэн хоёр хэлбэрээр ажилладаг. Төрийн болон хувийн шийдвэр гүйцэтгэгчдийн эрх зүйн баталгааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нарын эрх зүйн байдал ба шийдвэр гүйцэтгэх журмын тухай хуульд ялгаатай зохицуулсан бөгөөд төрийн шийдвэр гүйцэтгэгчдийн бүтэц, зохион байгуулалт, материал ба эд хөрөнгө, техник тоног төхөөрөмжийн хэрэгцээг жил бүрийн улсын төсөвт тусгаж, төрөөс хангадаг ба шийдвэр гүйцэтгэгчдийн оршин суугаа газрыг нууцлах асуудлыг мөн хуульчжээ.

Энд сонирхуулахад хувийн шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь эрх бүхий төрийн байгууллагаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа явуулах эрхийг авсан хүмүүс байдаг ба тусгайлан хуулийн этгээд байгуулах шаардлагагүй байдаг. Хувийн шийдвэр гүйцэтгэгчид нь өөртнөхандсанхувьхүнболонхуулийнэтгээдийнэрхашгийнтөлөөшаардлагатайшийдвэргүйцэтгэлийнүйлажиллагааявуулдаг ба үйл ажиллагаагаа явуулахтай холбоотой бүхий л зардлаа өөрсдөө хариуцдаг.

Европын ихэнх улсад хэрэгжсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх Франц загвар ёсоор иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг Хууль зүйн яамнаасаа зөвшөөрөл авсан, хууль зүйн боловсрол эзэмшсэн хувь хүмүүс гүйцэтгэдэг энэхүү тогтолцоо зөвхөн Казахстан төдийгүй Франц, Голланд, Итали, Словени, Польш, Румын, Эстони, Латви зэрэг улсуудад хэрэгжих байгаа бөгөөд иргэний эрх зүйн хэлцэл байгуулах замаар шийдвэр гүйцэтгэлийг явуулж, өөрсдийн эрх зүйн болон нийгмийн асуудлаа бие даан бүрдүүлж ажилладаг байна.

Энэ мэтээр шийдвэр гүйцэтгэгчдийн орон байрны халдашгүй, аюулгүй байдлыг хамгаалах, түүний талаарх мэдээллийг нууцлах эрх зүйн зохицуулалтыг манай улсад бий болгох талаар судалж, шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Дараагийн нэг асуудал бол шийдвэр гүйцэтгэгчдийг осол, гэмтлийн даатгалд хамруулах явдал юм.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын болон цагдан хорих газрын ажилтнуудыг улсаас даатгалд хамруулах ба ажил үүргээ гүйцэтгэж явахдаа нас барсан, эсхүл осол гэмтэлд өртсөн тохиолдолд нөхөн төлбөр олгох тогтолцоог ОХУ-д нарийн чанд

хуульчилжээ. ОХУ-ын Эрүүгийн хариуцлагыг хорих ялаар гүйцэтгэх байгууллагуудын тухай хуулийн 34 дүгээр зүйлд “Хэрэв албан үүргээ гүйцэтгэж байхдаа амь насаа алдсан, эсвэл осол гэмтэлд өртсөн, өвчилсөн тохиолдолд түүний ар гэрийнхэн буюу тэжээн тэтгүүлдэг байсан хүмүүст 120 сарын цалинтай нь тэнцэх нэг удаагийн тэтгэмжийг тэнцүү хувааж олгоно. Хэрэв албаны үүргээ гүйцэтгэж байхдаа гэмтэл авч, түүнээс шалтгаалан хөдөлмөрийн чадвараа алдсан буюу цаашид албан үүргээ гүйцэтгэж чадахааргүй болсон тохиолдолд 60 сарын цалинтай тэнцэх мөнгөн тэтгэмж олгоно.” гэж заасан байдаг.

Киргизстан улсын гүйцэтгэх үйл ажиллагааны болон шүүхийн гүйцэтгэгчийн тухай хуульд зааснаар шийдвэр гүйцэтгэгч болон гүйцэтгэх албаны ажилтан нь амь насны заавал даатгалд хамрагддаг ба зардлыг төрөөс даадаг.

Харин АНУ-д эрүүгийн хэргийн шийдвэрийг Federal Bureau of Prison буюу Холбооны хорих ангийн товчоо гүйцэтгэдэг. Тус байгууллагын ажилтнуудыг анх ажилд орсон өдрөөс нь эхлэн амь насны даатгалд мөн адил заавал хамруулдаг байна. Улсаас тус даатгалын 60%-72%-ийг төлдөг ба ажилтан 28%-40%-ийг өөрөө төлдөг байна.

Түүнчлэн тус улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтнийг эрэн сурвалжилж олох, шүүхийн шийдвэрээр хураагдсан өмч, эд хогшлыг хамгаалах, хураагдсан өмчийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах чиг үүрэг гүйцэтгэдэг Маршалын албаны ажилтнууд ажилд ормогц амь насны даатгалд заавал

хамрагддаг ба өөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс биедээ галт зэвсэг авч явахыг хуулиар зөвшөөрсөн байдаг.

АНУ-д Маршалын алба, Холбооны хорих ангийн товчооны ажилтнуудыг албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан болон түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учирсан тохиолдолд тэдгээрийн амь нас, аюулгүй байдлыг төр хамгаалдаг ба тэдгээр албан хаагчдыг хамгаалах тусгай нэгжийг байгуулан ажиллуулж байна.

АНУ-д иргэний болон эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнууд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлснээс үүсэх үр дагаврыг өөрсдөө хариуцахгүй байхаар эрх зүйн баталгааг бүрдүүлсэн нь тэдний хараат бусаар ажиллах нөхцлийг бүрдүүлж өгдөг байна. Тодруулбал тухайн ажилтан хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхдээ аливаа хууль тогтоомж, дүрэм журам, албаны хэм хэмжээг зөрчөөгүй тохиолдолд түүнээс үүдэн гарах хохирол, гэм хорыг төр хариуцан арилгадаг. Харин чиг үүргээ хэрэгжүүлэх явцад алдаа гаргасан бол мөн учирсан хохирлыг төр хариуцаж, дараа нь тухайн гэм буруутай албан хаагчаар нөхөн төлүүлдэг.

3. Шийдвэр гүйцэтгэгч үйл ажиллагаагаа хараат бусаар, бусдын нөлөөнд автахгүй явуулах наад захын хангамж бол түүний цалин хөлсний баталгаажуулалт.

Дэлхийн улсуудад шийдвэр гүйцэтгэгчдийн нийгмийн баталгааг харилцан адилгүй хэдий ч өндөр түвшинд хангасан байдаг. ОХУ-д шийдвэр гүйцэтгэх аль төрлийн байгууллагад ажиллаж байгаагаас хамааран үндсэн цалингаас гадна 15-50 хувийн цалингийн нэмэгдэл олгодог.

Жишээ нь халдварт өвчнөөр өвчилсөн хоригдлуудыг тусгайлан хорих ангид ажиллаж буй шийдвэр гүйцэтгэгчдэд цалингийн 25 хувийн нэмэгдэл олгодог ба насаар нь хорих ялаар шийтгэгдсэн ялтнуудыг хорих ангийн ажилтнуудад цалингийн 30 хувийн нэмэгдэл олгодог байна.

АНУ-ын эрүүгийн хэргийн шийдвэрийг гүйцэтгэдэг Холбооны хорих ангийн товчооны ажилтнуудын цалин нь хашиж буй албан тушаал болон газарзүйн байрлалаас хамааран ялгамжтай тогтоогддог ороо ОХУ-тай төсөөтэй. Мөн 16 цагаас шөнийн 00 цаг хүртэл ажилладаг албан хаагчид нь жирийн цагийн үнэлгээнээс тодорхой хувиар илүү цалин авдаг ба амралтын өдрөөр үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчид 25%-ийн нэмэгдэл авдаг байх жишээтэй.

АНУ-ын Холбооны хорих ангийн товчооны ажилтан тасралтгүй 20 жилхорих ангид албан хаасан тохиолдолд 50 наснаасаатэтгэвэртгарах эрхтэй байдаг ба түүний тэтгэврийн хэмжээг ажиллаж байсан үеийн цалин хөлсний хэмжээнээс багагүй хэмжээгээр тогтоодог байна. Түүнчлэн зөвхөн хорих ангиар хязгаарлагдахгүйгээр тасралтгүй 25 жил ажилласан тохиолдолд нас харгалзахгүй тэтгэвэртээ гарах эрх нь нээгддэг байна. Тус улсын нийгмийн даатгалын тогтолцоо ёсоор Холбооны хорих ангийн товчоонд ажиллаж байсан хүн тэтгэвэртээ гарсан тохиолдолд улсаас нэмэлт орлого олох эх үүсвэрийг нь бүрдүүлж өгөх буюу ачаалал бага өгөх аж ахуйн нэгж, үйлдвэрийн газарт ажиллах боломжийг хангаж өгдөг.

3. Шийдвэр гүйцэтгэгчийн орон байрны болон бусад төрлийн хангамж

Шийдвэр гүйцэтгэгч албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай бас нэгэн энгийн баталгаа бол түүний орон гэр, унаагаар хангагдах боломжтой байх нөхцөл юм.

Оросын шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнууд бусад орон нутагт томилолтоор ажиллах тохиолдолд ямар нэгэн дараалал, хүлээлтгүйгээр бүх төрлийн тээврийн хэрэгслээр зорчих тасалбар авах эрхтэй ба зочид буудалд үнэ төлбөргүй байрлах эрхтэй байдаг. Украин улсад шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ аливаа тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорих эрхтэй байдаг.

АНУ-ын Холбооны хорих ангийн товчооны ажилтнуудын ажил руугаа нийтийн тээврийн хэрэгслээр ирэх зардлыг сард 230 ам.доллараар тооцон олгодог ба томоохон хотуудад ажиллагсад нь нийтийн тээврээр үйлчлүүлсэн илүүдэл зардлаа нөхөн төлүүлж авдаг.

Оросын холбооны улсад шийдвэр гүйцэтгэгчдийн нийгмийн баталгааг өөрийн орны онцлог нөхцөл байдалд нийцүүлэн бүрдүүлсэн байна. Жишээ нь шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнуудыг тус улсын аль нэг хэсэгт удаан хугацаагаар шилжүүлэн ажилуулах тохиолдолд тухайн ажилтны орон гэр, гэр бүлийг нүүлгэхтэй холбоотой зардлыг төрөөс бүрэн хариуцдаг ба 2 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгох, замд явах хоногийн зардлыг гэр бүлийн гишүүдийн тоогоор олгох, 20 хүртэлх тонны ачааг агаарын хөлгөөс бусад бүх төрлийн тээврийн хэрэгслээр үнэгүй тээвэрлүүлэх эрх олгодог. Үүнтэй төсөөтэй харилцааг манай улсад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 137.1.5 дахь заалтаар зохицуулсан билээ.

ОХУ-д мөн их сургууль төгсөөд шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллахаар ирсэн шинэ албан хаагч болон анх удаа гэрлэлтээ батлуулсан ажилтанд орон гэрээ төвхнүүлэхэд нь зориулж нэг удаагийн мөнгөн тусламж олгох хангамжийн тогтолцоог нэвтрүүлсэн байна.

Казахстанд шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь албан үүргээ гүйцэтгэж байх үедээ амь нас, эрүүл мэндээрээ хохирсон тохиолдолд тус улсын орон сууцны нөөцийн сангаас орон сууцаар хангадаг байна.

4. Монгол Улсын тухайд

Монгол Улсад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны эрх зүйн баталгааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Төрийн албаны тухай хуулиудаар зохицуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 137 дугаар зүйлд хуульчлахдаа албан үүргээ гүйцэтгэж байх үедээ нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон зардлыг тогтоосон журмын дагуу байгууллагаас нөхөн авах, албан үүргээ биелүүлж яваад амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь түүний 5 жилийн үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгох, албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан бие махбодид нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тахир дутуу болсон тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүүг хөдөлмөрийн чадвар түр алдсан, тахир дутуугийн тэтгэмж авч байсан нийт хугацаанд олгох ба хэрэв дээр дурдсан шалтгаанаар хохирсноос хиймэл эрхтэн хийлгэх, сонсголын аппарат авах, нөхөн сэргээх бусад эмчилгээ хийлгэх бол зардлыг улсын төсвөөс авах, жижүүрийн

үүргийг 24 цагаар гүйцэтгэж байгаа офицер, ахлагч нар байгууллагын зардлаар хооллох, шилжин томилогдох үед гэр бүлийн гишүүд болон ачаа тээшийг байгууллагын тээврийн хэрэгслээр хүргэх боломжгүй бол шаардагдах зардлыг автомашин, төмөр замын тээвэрт тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцож олгох гэх мэт эрх зүйн болон нийгмийн баталгааг түлхүү хуульчилсан байна.

Мөн төрийн албан хаагч болохын хувьд Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан төрийн албан хаагчийн баталгаагаар давхар хангагдах бөгөөд:

- гүйцэтгэж байгаа албан үүргийнх нь шинж байдлыг харгалзан зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардлын зохих хэсгийг нөхөн авах;
- албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүн нь тухайн төрийн албан хаагчийн ажиллаж байгаа төрийн байгууллагаар хамгаалуулах;
- төрийн алба хаах хугацаанд болон тэтгэвэрт гарсан үедээ хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах; зэрэг эрх зүйн болон нийгмийн баталгааг дурдаж болно.

Эцэст нь тэмдэглэхэд материаллаг шинжтэй эрх зүйн болон нийгмийн баталгаануудаас гадна хамгийн чухал нь шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны үед хөндлөнгөөс бусад этгээд оролцохгүй байх, шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны дагуу тавьсан шаардлагыг хүлээн авсан этгээд заавал биелүүлэх, хэрэв биелүүлээгүй